



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 25. өдөр

Дугаар 1/25

Мандалговь

С.Энхлэнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын угуул, Монголын Спортын дунд сургуулийн тамирчин Сугаррагчaa овогтой Энхлэнг Болгар Улсын Софи хотод зохион байгуулагдах Таеквондогийн Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 1,000.000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

4822111111